

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг**

|                                          |      |
|------------------------------------------|------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>   | 1    |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | 2-3  |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | 4-16 |

- 
- |                                                                                                                                                                                                                |      |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| 1. <b>“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</b> | 4-16 |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
3 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 58 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Бум-Очир, Э.Болормаа, З.Мэндсайхан, Н.Номтойбаяр;

Тасалсан: Ч.Анар, Л.Гантөмөр, Б.Жаргалан, Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, Г.Очирбат, Ө.Шижир.

**Нэг. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Д.Ганбат, П.Наранбаяр, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 42 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 40 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
10 цаг 58 минут.

### **АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцийн мэдээг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Сүрэнжавын Лүндийэг гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбаагийн Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ингээд 3 сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх 2 асуудал байгаа.

1 дүгээр асуудал. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийн төсөл /Засгийн газар өнгөрсөн оны 12 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/ байна.

2 дугаар асуудал. Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Гадаад харилцааны сайдын мэдээлэл байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Алга байна Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал.

**“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай” хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.**

Ингээд уг төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир сайд танилцуулна. Ингээд Аубакир сайдын микрофоныг өгье.

**Т.Аубакир:** Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас гадаад улсад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний нэг нь Монгол Улсын иргэд олноор оршин сууж байгаа улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулж, 2 улсын иргэдийн нийгмийн хамгааллын харилцаанд харилцан тэгш эрхтэй байх, тухайн улсын иргэний нэгэн адилаар тэтгэвэр, тэтгэмж авах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж

ирлээ. Одоогийн байдлаар ОХУ, БНСУ, Унгар Улс, БНПУ, БНТУ, БНЧУ, БНКАУ-тай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулж, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох, шимтгэл төлсөн хугацаанд ноогдох тэтгэвэр тогтоолгон авах, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах талаар харилцан тохиролцон хэлэлцээрийг хэрэгжүүлж байна.

Цаашид Австралийн холбооны улстай хэлэлцээр шинээр байгуулах, ОХУ, БНСУ-тай байгуулсан хэлэлцээрийг шинэчлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн БНАУ-тай 2023 оноос Нийгэм хамгааллын тухай Монгол Улс болон БНАУ-ын хоорондын хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлж, 2 улсын дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар хэлэлцээрт 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо талууд гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээр нь нийгмийн даатгалын хуулиудад зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д зааснаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ юм. Уг хэлэлцээр хэрэгжсэнээр иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг 2 улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, 2 улсад ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ноогдох тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдэж, тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа нь сайжрах юм.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт хөрөнгийн эх үүсвэр шаардагдахгүй юм.

Эрхэм гишүүд та бүхнийг хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Аубакир сайдад баярлалаа. Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Гишүүдийн нэрсийг авъя. Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Жангабыл гишүүн асуулт асууна.

**Х.Жангабыл:** Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улс өнгөрсөн жил Казахстан улстай нийгэм хамгааллын чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Одоо Австрали улстай нийгэм хамгааллын хэлэлцээр соёрхон батлахаар оруулж ирсэн байна. Энэ бол их сайшаалтай хэрэг Австри. Монгол Улс бол Оросын Холбооны Улстай, Бүгд Найрамдах Солонгос

Улстай гэрээ байгуулах шаардлагатай байна. Яагаад гэхээр Оросын Холбооны Улстай нийгэм хамгааллын талаар хэлэлцээр нь 1981 онд байгуулсан байна. Одоо энэ хэлэлцээрээр цааш нь явна гэдэг чинь бас шаардлага хангахгүй л дээ. БНСУ-даа манай 1 сумын дайтай иргэд амьдарч байна. 50 мянган хүн. 2006 онд байгуулагдсан байна хэлэлцээр нь. Энэ хэлэлцээрүүдийг шинэчлэн байгуулах, хэзээ байгуулах юм бэ. Энэ тал дээр мэдээлэл авъя.

**Г.Тэмүүлэн:** Жангабыл гишүүний асуултад хариулъя. Сайд Аубакир.

**Т.Аубакир:** Манай Монгол Улсын хувьд маш олон иргэд дэлхийн маш олон улсад очиж ажиллаж байгаа. Нийгэм хамгааллын хэлэлцээр бол маш чухал. Ер нь бол яах вэ нийгмийн даатгалын шимтгэлийг зарим улс төрчид маань татвар гэж ярьдаг. Энэ бол огт татвар биш. Тийм учраас бодлогын яамны хувьд бол эдгээр улсуудтай бид нар хэлэлцээрээ байгуулаад, тэдгээр иргэдийн нийгмийн баталгааг хангаж явах нь маш чухал юм байгаа юм. Хөдөлмөрийн чадвар буурах, өндөр насанд гарах үед энэ чинь ганцхан л тухайн хүний амьдралын баталгаа болж байгаа учраас гадаад улсад саяын хэлэлцээр хийсэн улсууд дээр нийгмийн даатгалын шимтгэлийг харилцан төлсөн, хүлээн зөвшөөрөх гэх зэрэг ажлуудыг бид нар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тасралтгүй явуулж байгаа.

Таны асуусан асуултад зарим улсуудтай бид нар эргээд хэлэлцээрүүдээ шинэчлэх, цаг үетэйгээ нийцүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа. Одоо хамгийн сүүлд Казакстан улстай бид нар хэлэлцээрээ байгуулсан. Маш амжилттай болсон. Манай Улсын Их Хурал соёрхон батлангуут Казахстан Улс 1 сарын дотор баталчхаж байгаа юм. Эргээд өөрсдөө парламент дээрээ. Тийм учраас зарим улсуудын хэлэлцээр бол хуучирсан нь үнэн. Бид нар ОХУ зэрэг улсуудтай хэлэлцээрээ шинэчлэн батлах тухай ажлууд явж байгаа. Зарим асуултад манай ажлын хэсгээс нэмж хариулах хүмүүс байна уу.

**Г.Тэмүүлэн:** 5 номер.

**Л.Мөнхзул:** Улсын Их Хурлын гишүүний асуултад хариулъя. Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Оросын Холбооны Улстай байгуулсан 1981 оны хэлэлцээр нийгмийн даатгал мөн тэтгэвэр тэтгэмж, эрүүл мэндийн үйлчилгээг хамарсан өргөн хүрээний хэлэлцээр байсан. Уг хэлэлцээрийг шинэчлэн батлах асуудлаар Оросын Холбооны Улстай 5 удаагийн хэлэлцээрийг 2018 оноос хойш хийж байна. Ингээд Монголын талаас бол бүх хэлэлцээрийн төсөл эцэслээд Засгийн газрын гишүүдээс санал авч дууссан. ОХУ-аас хэлэлцээрийн талыг эцэслэн процесс дуусгахаар мөн Аюулгүй байдал, Нийгмийн бодлогын байнгын хороонд өргөн барих боломж бүрдэнэ. Тэгэхээр бид нар бол энэ жилдээ багтааж оруулж ирэх ийм зорилго тавин ажиллаж байна.

**Г.Тэмүүлэн:** Болсон уу. Ганбат гишүүн асуулт асууя. Хүлээж байгаарай. Жангабыл гишүүн тодруулах юм байна.

**Х.Жангабыл:** Саяын миний асуусан 2 улстай хэзээ байгуулах юм бэ. Олон иргэдийн нийгмийн баталгаа нь алдагдаж байна шүү дээ. Бид нарт байнга хүсэлт ирдэг. Тэгэхээр яамны зүгээс энийг бол эрчимтэй явуулах шаардлагатай байна. Ялангуяа энэ 2 улстай. Сая би хэллээ шүү дээ. БНСУ-д 50 мянган хүн амьдарч байна. ОХУ тухайн үед 2 талдаа ч гэсэн мэргэжилтнүүд ажиллаж байсан. Тэр

улсуудын нийгмийн баталгаа нь хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхээр тодорхой хугацаа хэлэх боломж байна уу.

**Г.Тэмүүлэн:** 5 номер. Мөнхзул дарга асуултад хариулъя.

**Л.Мөнхзул:** Оросын Холбооны Улстай байгуулсан 1981 оны хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Энэ хүрээндээ ОХУ-ын иргэд Монгол Улсаас нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж тогтоолгон авч байгаа. Мөн нийгмийн халамжаас тэтгэвэр тэтгэмж тогтоолгон аваад, хэлэлцээрийн үндсэн хэсэг маань хэвийн 2 орны талдаа мөрдөгдөж байгаа. Нөгөөтээгүүр сая Засгийн газрын тогтоол дээр бид нар бас нэмэлт, өөрчлөлт оруулж, ОХУ-ын Монгол Улсад цагаачлан суусан иргэдийн хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг авах тэр боломж нь бас мөн хангагдан хэлэлцээрийнхээ хүрээнд шийдэгдээд явж байгаа. Зөвхөн хэлэлцээрээр шинэчлэх ийм зайлшгүй шаардлага үүссэн. Монголын талаас процесс дууссан. Оросын Холбооны талаас дотооддоо хэлэлцээрийн төслийг эцэслээд, эцэслэлээ гэдэг албан мэдээ манайд ирүүлэх үед бид нар Засгийн газраас өргөн мэдүүлэх ийм бүрэн боломж бүрдэнэ. Тэгэхээр 2026 ондоо энэ асуудлыг шийдвэрлэх зорилт тавьж байгаа. Бүгд Найрамдах .../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Микрофоныг нэмж өгье. 5 номер.

**Л.Мөнхзул:** БНСУ-тай 2006 онд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулаад, хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Ингэснээрээ БНСУ-д тэтгэврийн болон бусад даатгалд төлсөн шимтгэлээ Монгол иргэд Солонгос улсаас гарч явахдаа буцаан авах энэ харилцаа үйлчилж байгаа. Харин энэ харилцааг хэлэлцээрээр шинэчлэн батлуулах саналыг бол Солонгосын талаас тавьж байгаа. Одоо бол хэлэлцээр хүчин төгөл төгөлдөр үйлчлээд, ингээд 2 талд шимтгэл зэрэг төлөхгүй нөхцөлтэйгөөр ингээд хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлээд явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Ганбат гишүүн асуулт асууя.

**Д.Ганбат:** Өнөөдөр Монгол цэргийн бахархлын өдөр. Дэлхийн хамгийн шилдэг цэрэг болох Монгол цэргийн баярын өдөр. Тэгээд бүх цэргийн алба хаасан, хаагаагүй ч гэсэн бүх эрчүүддээ энэ баярын өдрийн мэндийг хүргэе. Ялангуяа миний он жавууд болох Зүүнбаян, бас хил дээр алба хааж байсан хилчид дээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ их чухал асуудал хэлэлцэж байна. Их сайн байна. Ингээд бас Австри улстай энэ гэрээг байгуулах гэж байгаа юм байна. Дэмжиж байна. Гэхдээ ер нь хэдий хэр хэмжээний хүмүүс гадаадад ажиллаад байна вэ. Ер нь 300-аад мянган хүн гадаадад ажиллаж байгаа байх. Энэ МАН сүүлийн 10 жил ингээд засаглаж байх үед энэ ядуурал чинь 30 хувиас буудаггүй. Тэгээд уг нь Нийгмийн хамгааллын яам байгаад байдаг. Тэгээд одоо 80 хувь нь гадагшаа гарч амьдрах, ажиллах хүсэлтэй гээд байгаа. Ийм судалгаа үнэн үү. Эх орондоо ажиллаж амьдрах ийм боломжгүй болтол нь ингэж засаглаж байгаа нь аягүй харамсалтай байна. Энийг та бүхэн юу гэж үзэж байна. Яаж байна. Энэ талаар бас нэг сонсмоор байх юм.

Тэгээд энэ гадаад, дотоодод ажиллаж байгаа хүмүүсийн хэдэн хувь нь миний ойлголтоор хамгийн 3D гэж ярьдаг тийм ажлуудыг л хийж байгаа шүү дээ. Derty, Difficult, Dangers гэсэн. Тэгээд нийгмийн даатгалаа тэр гадаадад төлчхөөд энд ирээд авч байгаа цалин тэтгэвэр нь ямар байдаг юм бэ. Хэдийг өгдөг юм бэ. Тэнд бол

мэдээж хэрэг хамгийн хүнд хэцүү, бохир ажлыг хийж байгаа ч гэсэн ямар ч байсан 1 мянган долларын цалин хаана ч гэсэн аваад байдаг юм шиг байгаа юм. Тэгээд тэр нийгмийн даатгалаа төлснийх нь шимтгэлийг нь аваад энд ямар хэмжээний нийгмийн даатгалыг нь өгдөг юм бэ. Өнөөдөр нийгмийн даатгалын хэмжээ үнэнч шударга зөв байж чадаж байна уу. Энэ тогтолцоогоо өөрчилнө гээд яриад л байдаг. Өнөөдөр амьдрал дээр одоо болтол байдаггүй. Иймэрхүү асуудлууд байна.

Тэгээд уул нь жилд 100-аад мянган хүн төрдөг байсан. Монголчууд цөөхөн л дөө. 10-аад сая Монголчууд дэлхий дээр байна гээд байгаа. 3 сая 500 л одоо Монголдоо байна. Гэтэл төрөлт 100 мянгад хүрч байсан. Сүүлийн жилүүдэд маш их буурч байна. Одоо бараг 40, 50 мянгатай болчихсон уу. Хэрэв төрөлт ингээд буурчихвал ахиад ихсэхэд маш хүнд байдаг, хэцүү байдаг. Тэгээд бид нар чинь ингээд ийм яамтай. Тэгээд танайх бас энэ МАН чинь халамжийн бодлогыг маш сайн хэрэгжүүлдэг, тэгээд их ард түмний хувьд.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Аубакир сайд асуултад хариулъя.

**Т.Аубакир:** Ганбат ахдаа бас цэргийн баярын мэнд хүргэе. Тэгээд яах арга байхгүй манай танкчин ах маань. Тэгээд та маш зөв асуудал хөндөж байна. Тэгэхдээ энэ бол МАН гээд нэг улс төрийн хүчин нөлөө гэхээсээ илүү энэ төрөлт буурч байгаа явдал бол зөвхөн ганцхан манай Монгол Улсын проблем биш болсон Ганбат гишүүн ээ. Франц улс маань 2025 онд анх удаа нас баралт нь төрөлтөөсөө илүү гарлаа. Хятад улс 2025 онд түүхэндээ хамгийн бага хүүхэд төрсөн жил боллоо. Япон, Солонгос, Европ ямар байдалтай болж байна тээ. Тийм учраас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас төрөлтийг дэмжих бодлогуудаа хуулиудаараа дамжуулаад, хэрэгжүүлээд явж байгаа. Удахгүй хуулиуд орж ирнэ. Та бас дэмжиж өгөөрэй. Төрөлтийг дэмжинэ гэдэг бол энэ өөрөө дэлхийн ихэнх улсуудын асуудал болчихсон учраас манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 3 ба түүнээс дээш хүүхэдтэй, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй бол эдийн засгийн мотиваци, сэдлүүдийг өгөх зорилгоор эдийн засгийн хөшүүргүүдийг оруулсан ийм хуулиуд маань орж ирж байгаа.

Гадагшаа гарч ажиллаж байгаагийн хувьд зөвхөн манай Монгол Улсаас хүмүүс гадагшаа явж ажиллаад байгаа юм биш ээ. Японы залуучууд судалгаагаар Австрали улсад очиж ажилламаар байна гэдэг судалгаа маш өндөр гардаг. Энэ маань нэг талдаа залуу хүний өөр газар шилжиж очиж ажиллах, магадгүй сониуч зантай холбоотой байж магадгүй. Нөгөө талдаа мөн цалингийн асуудал бол яах аргагүй бас нэг фактор. Тийм учраас бид нар гадагшаа явж ажиллаж байгаа залуучуудаа зүхээд, эх орноосоо явлаа эсвэл Монгол үнэхээр муудчихаад, хүн амьдрахын аргагүй болчихоод яваад байгаа зүйл гэж бас мушгиж бас болохгүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын хамгааллын яамнаас 2026 оныг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгож зарласан. Энэ хүрээнд бид нар айхтар тийм аян зарлаад, попрод ингэхгүйгээр бид нар өмнөх ажлаа зүгээр мөрөөрөө дуугүй л хийгээд явж байгаа. Энэ хүрээнд бид нар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаараа дамжуулаад бид нар хөдөлмөр эрхэлбэл ийм ийм хөшүүргүүд үзүүлье, бид нар халамж биш хөдөлмөрлөдөг байгаач гэдэг бодлогыг Хөдөлмөрийн яам бол илүүтэй бариад явж байгаа. Халамж гээд ярихаар энд бид нар айхтар цочоод сүйд болоод байх зүйл биш. Яах арга байхгүй зорилтот бүлэгтэй бид тэр халамжаа өгдгөөрөө өгнө. Зайлшгүй. Яг цэвэр дүнгээрээ бол 500 орчим тэрбум төгрөг л хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа асаргааны тэтгэмж гэх зэрэг нийгэмд бол халамж шаардлагатай хэсгүүд

байгаа шүү дээ. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол халамж гэхээсээ илүү та ерөөсөө хөдөлмөрлөөч ээ гэдэг хөдөлмөрлүүлэх зорилгыг л хамгийн урдаа тавьж ажиллаж байгаа.

Гадаад улсад яг ажиллаж байгаа зарим тоо статистикуудыг манай хэд маань тайлбарлана биз. Тэгээд зөвхөн манай Монгол залуучууд маань эх орон нь муухай болохоор яваад байгаа зүйл огт биш шүү. Японы залуучууд бид нар Австралид очиж ажилламаар байна гэж хэлдэг. Тийм учраас энэ бол зөвхөн Монгол улсад хүн амьдрахын аргагүй болчихоод зугтаагаад байна гээд ингээд нийгэмд буруу ийм зүйл хэлээд байж ерөөсөө болохгүй. Дэлхийн бүх улс орны залуучууд маань өөр орчинд, өөр оронд очиж ажиллах ийм хүсэл зорилготой байдаг юм байна лээ.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулт өгье. 6 номер.

**Ц.Ганцэцэг:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ганцэцэг.

Гадаад хэргийн яамны 2025 оны эхний хагас жилийн мэдээгээр нийтдээ 51 улсад 266 мянган Монгол Улсын иргэн ажил хөдөлмөр эрхэлж амьдардаг юм байна. Манай салбарын хувьд бол нийтдээ 6 улсаа нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулсан. Энэ хэлэлцээрийн хүрээнд жилдээ 2 мянга орчим Монгол Улсын иргэн нийгмийн хамгааллын үйлчилгээг аваад явж байна. Бусад улсад ажиллаж байгаа хэлэлцээргүй орнуудын хувьд бол Монгол Улсын иргэд нийгмийн даатгалдаа Монголдоо сайн дурын үндсэн дээр даатгуулах эрх нь бол нээлттэй. Нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөд хэрвээ хуульд заасан нөхцөл боломжийг хангаад явбал Нийгмийн даатгалын хуулийн дагуу тэтгэвэр тэтгэмжээ авах ийм боломж нь болбол нээлттэй байгаа.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Нийтдээ 266 мянган хүн гадаадад ажилладаг юм байна. Энэ хүмүүс маань яг ямар ажил эрхэлж байна вэ. Энэ талаар та бүхэнд судалгаа, тоо баримт байна уу. Нөгөө талаар Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан ер нь бүх санг л луйвардаад хулгайлаад байхгүй болгочихдог л доо. Тэгээд ЖДҮ сан бүгдийг нь л зээл аваад ингээд дуусгачихдаг. Тэр сангууд маань ямар байна вэ. Одоо манай иргэд эрүүл мэндээ үзүүлэх гээд, эмнэлэгт хэвтэх гээд энэ даатгалын сан нь ажиллахгүй байна гэсэн ийм гомдол байна. Хүсэлт байна. Тэрийг нь төлбөрийг нь хийдэггүй учраас эмчлүүлж чадахгүй ийм байдалтай байна гэж байна. Энэ байдал яг ямар байгаа вэ.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Аубакир сайд.

**Т.Аубакир:** Манай яг нийгмийн даатгалын тогтолцоо бол асар тийм муу тогтолцоо бол ерөөсөө огт биш. НҮБ-д бүртгэлтэй 193 улсаас 160 улс нь яг манай тогтолцоогоор явж байгаа. Дэлхий дээр зарим улсууд хуримтлалын тогтолцооноос татгалзаж эхэлж байна. Унгар, Польш, Чили гэдэг зэрэг улсууд жишээлбэл энэ хуримтлалын сан бас болох болохгүй юм байна. Яагаад гэхээр тэр маань нөгөө даатгуулагчийн мөнгийг өсгөх үүрэг хүлээчихдэг. Тэгээд нөгөө хуримтлалын сан маань мөнгөө яаж өсгөх вэ, мэдээжийн хэрэг гуанз, ресторан ажиллуулахгүй. Хөрөнгийн зах зээл рүү хийдэг. Хөрөнгийн зах зээл нь өөрөө савлагаатай учраас иргэний нийгмийн баталгаа савлагаатай байж болохгүй юм байна гэж үзэж байгаа юм. Тийм учраас тогтолцоондоо огт буруу байгаа зүйл ерөөсөө байхгүй. Ямар

сайдын үед нийгмийн даатгалын сан маань янз бүр болсныг та бүхэн сайн мэдэж байгаа. Одоо хүний нэр хэлээд яах вэ. Одоо бол манай сан маань тодорхой хэмжээнд бас сайжраад явж байгаа. Энэ дээр ний нуугүй хэлэхэд зарим улс төрчдийн улс төртэй хуулиуд гаргасны уршгаар нийгмийн даатгалын төрийн татварын мөнгөөр татаастай явж байгаа нь .../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Аубакир сайд нэмж хариулъя.

**Т.Аубакир:** Өнөөдрийн байдлаар нийгмийн даатгалын санд 1,3 сая гаруй мянган иргэн яг даатгуулаад нийгмийн даатгалын шимтгэл төлөөд явж байгаа. Нөгөө талдаа 537 мянган иргэн тэтгэвэр аваад явж байгаа. Тийм учраас бид нар нийгмийн даатгалын би түрүүн бас үгнийхээ эхэнд хэлсэн. Манай зарим улс төрчид маань нийгмийн даатгалын шимтгэл бол татвар юм гэж ярьдгаа болимоор байна. Энэ маань өөрөө тэр иргэний нийгмийн баталгаа. Хэн ч тэр иргэний нийгмийн баталгааг хангаж өгөхгүй.

Тийм учраас татвар гэдэг бол тусдаа ойлголт. Нийгмийн даатгалын шимтгэл гэдэг бол тухайн иргэний нийгмийн баталгаа учраас бид нар энэ нийгмийн даатгалынхаа санд аливаа улс төр орсон зарим салбарын хүмүүсийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж өгдөг. Сайрхаж тийм ээ. Тийм учраас иймэрхүү улс төртэй шийдвэрүүдийг бид нар улс төртэй өнцгөөр бид нар хуулиудыг оруулахгүй баймаар байна гэдгийг хэлье. Тийм учраас манай нийгмийн даатгалын сан бол асар муудаагүй ээ. Маш сайн явж байгаа. Өнгөрсөн 2025 онд бид нар дахиж 20 мянга орчим иргэн шинээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч болсон. Зарим тоон дээр манайх хариулах уу.

**Г.Тэмүүлэн:** Хэн нэмж хариулах вэ. 6 номер.

**Ц.Ганцэцэг:** Гадаад хэргийн яамнаас авсан тоог тодруулъя. 266 мянган хүн гэдэг дотор бол хүүхдүүд бас ороод явж байгаа. Яг ямар салбар, ямар үйл ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа тодорхой мэдээллийг бол бид нар нэмэлтээр авъя гэж ингэж бодож байгаа. Одоохондоо бол Гадаад хэргийн яамнаас аваагүй байна.

**Г.Тэмүүлэн:** Австрид хэдэн хүн ажиллаад байна.

**Ц.Ганцэцэг:** Австрид Монгол Улсын 2696 иргэн ажиллаж, амьдарч байна. Үүнээс яг 1700 орчим нь тодорхой хөдөлмөр эрхэлж байна. Орчуулга хийж байна. Такси үйлчилгээ хийж байна. Ийм чиглэлээр ажиллаж байгаа иргэд бол Австрийн хэлэлцээрт бас хамрагдах ийм боломжтой. Монгол Улсад бол Австрийн 30 хүн үндсэндээ ажиллаж, амьдарч байна.

**Г.Тэмүүлэн:** Болсон уу Ганбат гишүүн ээ. Дараагийн гишүүн асуулт асууя. Наранбаяр гишүүн.

**П.Наранбаяр:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Юуны түрүүнд эр цэргийн баярын мэндийг хүргэе. Монгол цэрэг бол НҮБ-ын тавцан дээр Монгол эр хүний, Монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөж байгаагаар бид ямагт бахархаж байдаг.

Юуны хувьд бол энэхүү Австрийн нийгмийн хамгааллын тухай энэ хэлэлцээрийг бол дэмжиж байна. Монгол Улс өнөөдөр 6 улстай байгуулсан байдаг

юм байна. Тэгэхээр миний асуулт бол Япон улстай хэзээ байгуулах вэ. Та бүхний өгсөн мэдээллийг харахад гадаадад 210 мянган Монгол хүн байна гэж бичсэн байна. Гэвч одоо хариулахдаа ГХЯ-ны тоогоор 266 гэж даруй 56 мянгаар өсгөж байна. Тэгэхээр энэ тоон дээр анхаараарай чуулганаар оруулаад ирэхэд нэгдсэн 1 тоо байх хэрэгтэй. Тэгээд ингээд харахад Америк тивд бол яг энэ чиглэлийн хэлэлцээ 88 хувьтай явчихсан байдаг юм байна. Гэтэл Ази-Номхон далайн бүсэд 43 хувьтай. Япон улс 22 улстай байгуулсан гэж. Энэ хэлэлцээ яагаад энэ Ази-Номхон далайд ийм бага байна. Яагаад тоо нь цөөн байна. Ямар учиртай юм. Япон улстай хийж байгаа энэ хэлэлцээ нь яг энэ чиг хандлагатай нь бас уялдах уу, үгүй юу. Манайх хэлэлцээгээ хийгээд эхэлсэн үү. Эхлээгүй юу. Яагаад гэвэл тэнд 20 мянга гаруй Монгол хүн ажиллаж, амьдарч, суралцаж байгаа. 266-аар нь тооцох юм бол та бүхний өгсөн мэдээлэл 9 хувьтай гэхээр бараг 25 мянга орчим, 24 мянга орчим Монгол хүн ажиллаж амьдарч байна. Энэ нь бол Япон улстай хэлэлцээр явуулах өндөр шаардлагатай байгааг харуулж байгаа. Зүгээр бодитой жишээ хэлэхэд жишээлэх юм бол миний сайн мэддэг хүн 15 жил тэнд ажиллачхаад, нийгмийн өндөр шимтгэл, даатгалыг нь төлчхөөд, Монголд ирээд ингээд ажиллаж амьдарч байгаад өөд болсон. Гэвч тэнд амьдарсан мөнгөнөөс 1 нь ч орж ирээгүй. Яагаад гэвэл ийм хэлэлцээр байхгүй гээд. Тэгэхээр ийм нөхцөл байдалтай хүн зөндөө бий. Тэгэхээр зэрэг та бүхэн Япон улстай байгуулах энэ ажлыг хэр урагшлуулж байна. Ингээд харахад бол 6 улс нь бол үнэхээрийн олон байгаа улсууд байна. Гэтэл Ази-Номхон далайн бүс нутагт бол Монголчууд олноор суурьшиж байгаа шүү дээ. Энэ чиглэл рүү нь та бүхэн ямар ажил хийж байгаагаа тодруулан хэлж өгч болох уу. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Наранбаяр гишүүний асуултад хариулъя. 5 номер. Мөнхзул дарга.

**Л.Мөнхзул:** Гишүүний асуултад хариулъя. Наранбаяр гишүүний хэлсэн зүйлтэй бол санал нэг байна. Тэгэхээр Монгол Улсын хувьд бол хүн ам цөөтэй. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын тоо тухайн улстай харьцуулахад их цөөн байдаг. Нийгмийн хамгааллын хэлэлцээр хийхэд 2 орны харилцан дипломат урьдчилсан явж ирсэн харилцаан дээр маш их тулгуурладаг. Тэгэхээр одоо бид нарын байгуулж байгаа энэ гэр гэрээнүүд маань Европын холбооны улсын стандарт гэрээг ихэвчлэн байгуулж байгаа. Ази-Номхон далайн бүсээс анх удаа Австрали улстай байгуулахаар хэлэлцээрийг 3 удаа хийгдсэн. Эхний хэлэлцээрийн түвшин техникийн ажлын хэсэг энэ жил, 2025 онд өнгөрсөн жил хэлэлцээгээ бид хийгээд өнгөрсөн 11 дүгээр сард хийгээд буцсан. Австралийн талд мөн Монголын олон хүмүүс ажиллаж байгаа учраас Австралийн талтай хэлэлцээрээ энэ онд урагшлуулж түвшинд нь гаргах зорилт тавьж байна.

Мөн түүнчлэн Япон улстай Монголын нийгмийн хамгааллын асуудал хариуцсан 2 хүн Гадаад хэргийн яамны харьяанд ЭСЯ-нд ажиллаж байгаа. Түүгээр дамжуулан бид нар мэдээллийг авч ажиллаж байгаа. Тэгээд Япон талдаа бол бас цаашдаа ажиллах зорилт тавьж байна.

Дараагийн асуудал нь АНУ-д амьдарч байгаа монголчууд мөн нутаг буцах тохиолдолд шимтгэлээ буцааж авах тэр боломж нь хаалттай. Энэ асуудлыг хэлэлцээрийн асуудлыг урагшлуулах талаар мөн АНУ-д байгаа Монгол Улсын ЭСЯ-тай хамтран ажиллаж өмнө явсан хэлэлцээрүүдийн шатыг урагш ахиулах чиглэлээр ингэж харилцан хамтарч ажиллаж байгаа. Тэгэхээр энэ онд бид нарын гол зорилго бол Австрали улстай хэлэлцээрээ урагшлуулах, АНУ-тай хэлэлцээрийнхээ түвшнийг дараагийн түвшинд гаргах, 3 дугаарт Япон болон дахин монголчуудын олноор суурьшиж байгаа Швед зэрэг орнуудтай хэлэлцээний шатыг эхлүүлэх,

түргэтгэх ийм зорилтууд дэвшүүлж байгаа. Тэгээд энэ бол бас гадаад харилцааны асуудлын түвшинд харилцан уялдаатай явдаг учраас зарим улсууд бол хэлэлцээгээ илүү олон жил зарцуулдаг. Тухайлбал Оросын Холбооны Улстай бид нар 2018 оноос хойш хэлэлцээр хийгдэж байгаа боловч батлагдах түвшин маань арай удаашралтай явж байгаа гэх мэт зүйлүүд байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Батсүмбэрэл гишүүн асуулт асууя. Батсүмбэрэл гишүүн алга байна. Батсүмбэрэл гишүүнийг дуудаарай. Гишүүд орж иртэл би бас тодруулаад 1 асуулт асууя.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Аубакир сайд аа бид нар орон нутагт сая гишүүд тойрог дээр ажиллалаа. Тэгээд эргээд юу гэдэг юм. Манай төрийн албан хаагч нартай уулзахаар орон нутагт нэг талдаа юу гэдэг юм. Нөгөө цалин хөлсөөрөө бас хангалттай хэмжээнд байхгүй байгаа учраас төрийн албан хаагч нарын гадагшаа гарч хөдөлмөрийн зах зээлд гарч ажиллах энэ хандлага бол нэлээн бас их байгаа. 3 сараар гардаг. Виз нь гардаг. Ингээд дийлэнх нь Солонгос руу явж хар ажил хийх гэх юм уу даа. Тэгэхээр зүгээр та бүхэн маань яг иймэрхүү асуудлууд дээрээ хөдөлмөрийн эрх ашгийг нь хамгаалах, хүний эрхийг нь хамгаалах талаасаа яг бүртгэл хийж чадаж байна уу. Одоо юу гэдэг юм сая Солонгос чинь 50-60 мянган иргэд байна гэж байдаг. Гэтэл 3 сараар байнгын тогтмол манайхны зорчиж, тэнд хараар ажиллаж байгаа иргэд болоод, төрийн албан хаагч нарын эрх ашгууд бас тэнчээ хөндөгдөх асуудлууд гардаг. Энэ дээр тодорхой бүртгэл тооцоо мэдээллүүд хийж чадаж байна уу. Эргээд юу гэдэг юм энэ иргэдийн хөдөлмөрлөх тэр эрхийн хамгаалалтыг нь гэдэг юм уу, эсвэл хөдөлмөрийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлууд дээр ер нь бас яаж анхаарал хандуулж ажиллаж байна вэ.

Нэг талдаа сая би жишээ нь ингээд сум дээр ажиллаж байхад үндсэндээ энэ асуудлыг хөндөж тавьж байгаад бас иргэний төлөөлөл байгаа юм л даа. Энэ манай Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Ганчимэд гээд иргэн асуусан. Үндсэндээ Солонгост хар ажил хийдэг. Бид нар ингээд төрийн албан хаагч нар 3 сараар ажилладаг. Орчин нөхцөл хүнд байдаг, эрх ашиг хөндөгддөг. Эргээд тэнд байгаа гэдэг юм уу манай төрийн байгууллагууд бид нарын хөдөлмөрлөх эрхийг хамгаалахын төлөө бол хангалттай ажиллаж чадахгүй, цалин хөлс дутуу авдаг. Ингээд осол аваар, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой зөрчлүүд нэлээн гардаг. Тэгэхээр энэ дээр бас тодорхой бүртгэл тооцоолол хийж гэдэг юм уу, тодорхой бүртгэл эрхийг хамгаалах талаас нь бол анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна гэдэг асуудал ярьдаг.

Тэгэхээр би зүгээр Солонгосоор жишээ болгож ярьж байгаа боловч бид нар энэ дээр бас тодорхой иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах талаасаа бол энэ хууль бус статустай байна уу, хууль ёсных байна уу бүх иргэдээ л бүртгэлжүүлж, тодорхой мэдээллээр хангаж, эрх ашгийг нь хамгаалах тал дээр анхаарах, ажиллах зайлшгүй шаардлага байна л гэж хараад байгаа юм. Энэ дээр та хэд маань ер нь яг ямар тодорхой ажлууд хийж байна. Мөнхзул дарга 5 номер.

**Л.Мөнхзул:** Монголчууд хамгийн олноор хөдөлмөр эрхэлж байгаа улсуудын 1 нь бол БНСУ мөн. Үүнд болбол 50 гаруй мянга иргэн ажиллаж амьдарч байгаагаас 10 орчим мянган хүүхэд оршин суудаг гэсэн мэдээллийг Гадаад хэргийн яамнаас өгдөг. БНСУ-тай бас Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд ажиллах хүчийг манайх тодорхой Солонгос улсаас баталсан квотын хүрээнд Монголоос ажиллах хүч илгээдэг. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажиллагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор яамны салбар нэгж болох Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төвийг БНСУ-ын Сөүл хотноо ажиллуулдаг. Ингээд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол иргэдийн хөдөлмөрлөх эрх зөрчигдөх, цалин хөлсөө авч чадахгүй байх, үйлдвэрлэлийн осолд өртсөн тохиолдолд яаралтай эмнэлгийн тусламж авах зэрэг үйлчилгээг Монгол иргэдэд яаралтай холбон зуучлах зорилгоор энэ Солонгос дахь нэг цэг ажилладаг. Эдгээр 1 цэг дээр ажиллаж байгаа манай албан хаагчид болон БНСУ дахь Монгол Улсын ЭСЯ-ны бас мөн Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан атташе болон холбогдох мэргэжилтнүүддээ хамруулж энэ асуудлыг бол шийдвэрлэдэг. Нэлээд олон иргэдийн асуудлыг бол шийдвэрлэдэг.

Түүнчлэн Солонгост амьдарч байгаа хүмүүсийн хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахтай холбогдолтой энэ асуудал дээр Монгол иргэдээс их гомдол гардаг. Энэ асуудлыг шийдвэрлэдэг. Харин улирлын шинж чанартай болон түр зуур зорчих визээр, аяллын визээр очсон иргэд хөдөлмөрлөх эрх зөрчсөн асуудлыг хүсэлт ирсэн тохиолдолд нэг цэгийн үйлчилгээний албан хаагчид маань холбон зуучлах, орчуулгаар хангах, энэ тусламж үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж явдаг. Яг хэдэн хүн богино хугацаагаар ажиллаж байгааг бол энэ бүртгэлийг авах нь бас их тодорхой бус байдаг.

**Г.Тэмүүлэн:** Тэгээд гадаадад хараар болоод албан ёсоор ажиллаж байгаа иргэдийнхээ эрх ашгийг бас хамгаалах, хөдөлмөрийнх нь эрх ашиг хөндөгдөх энэ асуудлууд бас тодорхой анхаарч ажиллаарай л гэдгийг хэлэх байна.

Би дахиад ганц зүйл тодруулаад асуучихъя. Гишүүд орж ирж байх хооронд. Үндсэндээ та хэд маань төрийн бодлогын гол үндсэн чиглэл чинь яаж ядуурлыг бууруулах вэ, яаж ажилгүйдлийн түвшнийг л ерөөсөө багасгах вэ гэдэг л үндсэн рүү чиглэж байгаа юм. Яг эцсийн дүнд. Тэгэхээр энэ дотроо та хэд маань одоо ер нь өнөөдрийн байдлаар нийт ажилгүй иргэдийн тоо хэд байгаа юм. Ажилгүйдлийн түвшин хэд байгаа юм. Нийт Монгол Улсын ажиллах хүчний тоо, хэмжээ хэд байгаа юм. Би багцаагаар 1,3 сая гэж тооцоо аваад байгаа. Ингээд та бүхний статистик мэдээлэл бол ажилгүйдлийн түвшин нь 4,5-5 хувьтай ч гэдэг юм уу ийм тооцоо өгөөд байдаг. 50-60 мянган хүн гээд байдаг. Гэтэл яг бодит амьдрал дээр цаана чинь бараг 300 мянга гаруй иргэд гадаадад ингээд хараар болоод албан ёсоор тэнд ажил хөдөлмөр эрхлээд ингээд байж байна. Тэгэхээр бол Монгол төрийн хөдөлмөрийн бодлоготой холбоотой асуудал, нийгэм хамгаалал бодлогын асуудал бол үндсэндээ юу гэдэг юм тэр гадаадад байгаа, гадаадад хараар ажиллаж байгаа энэ иргэдийгээ буцаан татаж ажлын байраар хангах асуудал хөндөгдөх ёстой байгаад байгаа юм. Бодитоор тэр юу гэдэг юм өнөөдрийн ажилгүйдлийн түвшин 4, 5 хувь биш, үүн дээр нэмэх нь тэнд байгаа иргэдээ бид нар яаж Монголд ажилтай, оронтой, цалин хөлстэй байлгах вэ, Монголдоо ядаж яаж сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх вэ л гэдэг асуудал байх ёстой байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр та хэд маань ер нь яг ямар дүн шинжилгээ хийж, ямар бодлого гаргаж ажиллаж байна. Мөнхзул дарга. 5 номер.

**Л.Мөнхзул:** 2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 15 ба түүнээс дээш насны статистикийн аргачлал өөрчлөгдсөнтэй холбогдуулаад ер нь 15-аас дээш насны нийт хүн амыг хөдөлмөрийн насны хүн ам гэж тооцдог шинэ аргачлал руу шилжсэнтэй холбогдуулаад 15-аас дээш насны 2,3 сая хүн ам байгаад байгаа. Үүний 61,3 хувь нь ажиллах хүчин гэж тооцогдож байгаа. 911 мянган хүн бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Энэ маань цэргийн албан хаагч нар, хүүхдээ асарч байгаа эхчүүд, мөн оюутнууд, мөн түүнчлэн өндөр насны тэтгэвэр аваад

хөдөлмөр эрхлээгүй байгаа иргэдийг оруулж тооцож байгаа юм. Ажилгүйдлийн түвшин бол 5,9 хувьтай гарсан 2024 оны байдлаар.

Монгол Улсын Засгийн газрын хувьд бол цаашдаа ажиллах хүчний оролцооны түвшнийг нэмэгдүүлэх, ялангуяа эмэгтэйчүүдийн дундах ажиллах хүчний оролцооны түвшнийг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлж байгаа. Учир нь гэвэл эмэгтэй хүний .../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Минут нэмээд өгье.

**Л.Мөнхзул:** Эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнээ асрах, ахмад настнаа асрах, хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх, хүүхдээ асрах энэ чиг үүрэгтэй холбогдолтойгоор өнөөдөр бол эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин бага байгаа. Тэгэхээр цаашдаа бол энэ асрахуйн эдийн засагт түшиглэсэн эдийн засгийг эрчимжүүлэх энэ асуудлаар бол яам зорилгоо дэвшүүлж байгаа. Энэ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг үнэлэмжтэй болгох асуудлыг бас дэвшүүлж байгаа. Мөн түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр дан ганц Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар жижиг хүрээнд ажиллах төдийгүй макро эдийн засгийн бодлогын түвшинд анхаарах зайлшгүй шаардлагатай байна гэдэг зорилтыг бас Эдийн засгийн хөгжлийн яамнаас дэвшүүлсэн. 2030 он хүртэл баримтлах бодлогуудад бол нэлээн тусгагдсан байгаа. Энэ дотроо бол дундаж цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлогыг бас нэлээд дэвшингүй оруулж ирж байгаа. Учир нь гэвэл Монгол Улсын дундаж цалин хөлс ДНБ-д эзлэх хувийн жин нь бусад орнуудтай харьцуулахад ижил төстэй орнуудтай харьцуулахад бол доогуур байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл нэрлэсэн цалингаас гадна бодит цалинг өсгөх, инфляцын түвшин тогтвортой байлгах, экспортыг нэмэгдүүлэх гэсэн эдийн засгийн макро бодлогын үр дүнд ажилгүйдэл буурна гэсэн макро эдийн засгийн ерөнхий бодлого явж байгаа. Яамны түвшинд бол ирэх жил халамж авч байгаа 5 мянган өрх дээр бүх 21 аймаг, 9 дүүрэгт ажиллаж хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх ийм зорилт дэвшүүлж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн үг хэлье.

**Д.Ганбат:** Ер нь их харамсалтай тоо баримтууд гарч байна. Тэгээд нийтдээ 300 мянгаад иргэд гадаадад ажиллана гэдэг чинь Монгол Улсын иргэдийн бараг 10 хувь нь байна шүү дээ нийт иргэдийн. Хөдөлмөр эрхлэх чадвартай 900 мянган иргэдийн бараг л 1/3 нь байна. Тэгээд энэ дээр бас дүгнэлт хийх хэрэгтэй. Ядуурал буурахгүй байна. Энэ яам маань энэ жил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгожээ. Тэгээд энэ юмаа уриа лоозонгийн хэмжээнд биш, үнэхээр ажил хэрэг болгоосой гэж бодож байна. Тэгээд 80 хувь нь гадагшаа явах ийм хүсэлтэй, эрмэлзэлтэй байна. Энэ бол бараг л аюулын харанга дэлдэж байна гэсэн үг.

Нийгмийн даатгалтай гэрээ гаднын улс орнуудтай хийж байгаа чинь энэ зөв. Нөгөө муу нэртэй Эрдэнийн үед чинь Солонгостой гэрээ хийж байлаа шүү дээ. Аубакир сайдын үед чинь 12 сард бас Казахстантай хийсэн байна. Энэ бол их сайн байна. Энэ мэтчилнээр та бүхэн ингээд энэ ажлаа сайжруулаад яваарай. Гэхдээ ер нь манай ганц нэгхэн залуучууд тэр дэлхийн хэмжээний ажил том компаниудад хийгээд байгаагаас биш, ихэнх залуучууд маань тэр айл нүүлгэх хамгийн хүнд хэцүү ийм ажлуудыг хийж байна.

Бас тэр 10 мянган хүүхэд бас гадаадад байгаа юм байна. Тэдний сурч боловсрох тэр боломж бололцоог нь та нар анхаарах хэрэгтэй. Төрийн албан хаагчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдээд байдаг. Тэгээд цалин хангамж нь ч гэсэн сайн биш байдаг. Ийм юман дээрээ та бүхэн анхаарах ёстой. Тэгсэн мөртөө одоо Монгол Улс бол хамгийн баялгийн их нөөцтэй ийм улс орон байгаад байдаг. Энэ МАН-ын үед л ийм болчхоод байна шүү дээ нөхөд минь. Өдрөөс өдөрт л амьдрал доройтоод байна шүү.

Одоо нийгмийн даатгалаа төлөөд байдаг. Тэр даатгал нь яг үйлчилдэггүй, эмнэлэгт хэвтэж чаддаггүй, цалин хангамж, тэтгэвэр нь бага байдаг. Хүрэлцээгүй амьдралд. Тэгээд мөрийн хөтөлбөртөө баахан уриа лоозон амлалт өгчихсөн байдаг. Одоо засаглаад тал хугацаандаа ирчихлээ. Тэгээд хоорондоо хэрэлдээд суугаад байдаг. Энэ ард түмнийхээ амьдрал ахуй юм хумыг бодмоор байна шүү. Бид нар бас хэлж ярих нь багадаад байх шиг байна. Цаашдаа ч нэлээн сайн хэлье гэж бодож байгаа. Энэ дээр анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүд баярлалаа. Аубакир сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан маань бас гишүүдийн асуусан асуулт болоод хэлсэн санал, зөвлөмжүүд дээр бас анхаарч ажиллаарай. Тэгээд үндсэндээ 300 мянга гэдэг бол өөрөө бас бага тоо биш. Анхаарлын дохио бол өгч байна гэсэн үг.

Тэгээд бид нар энэ хөдөлмөрийн болоод оюуны урсгал гадагшилж байгаа асуудлууд дээр бас бодитойгоор дүгнэлт хийгээд, эргээд юу гэдэг юм Монголын боловсролтой, чадалтай, мэргэжилтэй энэ залуучууд, ажиллах хүчнээ бас өөр улс руу шилжин суурьшихгүйгээр эндээ бас ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх тал дээр том бодлогын түвшинд бол анхаарч ажиллах шаардлагатай байна л гэдгийг бас анхаарч ажиллаарай.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Хуруугаа уншуулаарай. Бэлэн байгаа 7 гишүүн байна. 9 болсон байна. Тэмүүжин гишүүнийх ороогүй. Орчихлоо. Ингээд санал хураалтыг явуулъя.

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар дэмжигдсэн байна.

Санал хураалтыг явуулж дууслаа.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд танилцуулах ёстой байгаа. Лүндэг гишүүн танилцуулъя. Нэгдсэн хуралдаанд илтгэнэ.

Дараагийн асуудалдаа оръё.

Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Гадаад харилцаа сайдын мэдээллийг сонсьё гэсэн байгаа. Засгийн газраас сая Энхбаяр сайд орж ирээд Засгийн газраас энэ асуудлыг дараа 7 хоногт болгож хойшлуулах хүсэлтийг бас тавиулсан байна. Ингээд энэ мэдээллийг бас дараагийн 7 хоног болгож хойшлуулъя.

Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

11.40 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*